



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 01 өдөр

Дугаар А/419

Есөнбулаг

Хорио цээр, хязгаарлалт тогтоох  
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.22, 4.1.23, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3 дахь заалт, Эрүүл мэндийн тухай 11 дүгээр зүйлийн 11.1.4 дэх заалт, Мал, амьтны Эрүүл мэндийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.5 дахь хэсэг, Засгийн газрын 2018 оны 266 дугаар тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/160 дугаар тушаал, аймгийн Онцгой комиссын 2023 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн 15 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус аймгийн Цээл сумын Дэрстэй багийн нутаг дэвсгэрт тарваган тахлын хүний өвчлөлийн сэжигтэй тохиолдол илэрсэнтэй холбогдуулан тус сумын нутаг дэвсгэрт хорио цээрийн дэглэм тогтоож, эмнэлгийн яаралтай тусламж авахаас бусад тохиолдолд гадагш гарах хүн, тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөнийг 2023 оны 08 дугаар сарын 29-ний өдрөөс эхлэн хориглосугай.

2.Хорио цээр, хязгаарлалт тогтоосонтой холбоотойгоор Засгийн газрын 2018 оны 266 дугаар тогтоолоор баталсан "Хорио цээр, хязгаарлалтын дэглэмийн үед хэрэгжүүлэх үйл ажиллагааны журам", Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/160 дугаар тушаалын дагуу холбогдох арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж, хяналтын цэг ажиллуулж, эрүүл мэндийн асуумжийн хуудас бөглүүлэн, хяналтын цэгт үүрэг гүйцэтгэх бүрэлдэхүүнийг шуурхай томилж нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Онцгой байдлын газар, Эрүүл мэндийн газар, Цагдаагийн газар, Зооноз өвчин судлалын төвд тус тус үүрэг болгосугай.

3.Тарваган тахлын хүний өвчлөлийн сэжигтэй тохиолдол илэрсэнтэй холбоотойгоор халдварт өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр шуурхай арга хэмжээ авч, аймгийн Онцгой комиссыг мэдээллээр хангаж ажиллахыг Цээл, Төгрөг, Цогт, Шарга, Халиун сумдын Засаг дарга нарт, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын "Тарвагыг ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар агнахыг түр хугацаагаар хориглох тухай" 2017 оны А/278 дугаар тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Онцгой байдлын газар (дэд хурандаа Ц.Лувсанжамц), Эрүүл мэндийн газар (Г.Лхагважаргал), Цагдаагийн газар (хурандаа Н.Мэндбаяр), сумын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.


2.

4.Тарваган тахлын хүний өвчлөлийн сэжигтэй тохиолдлоос дээжилсэн лабораторийн шинжилгээний сорьцыг Зоонозын өвчин судлалын Үндэсний төвд шуурхай хүргүүлэхийг Зоонозын өвчин судлалын төв )Р.Наранбаатар(-т даалгасугай.

5.Хорио цээр, хязгаарлалт тогтоох, тарваган тахал өвчинтэй тэмцэхтэй холбоотой мэргэжлийн байгууллагаас авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардлыг аймгийн гамшгийн сангаас шийдвэрлэхийг Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-д зөвшөөрсүгэй.

6.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, Онцгой комиссын хурлыг тухай бүр шуурхай хуралдуулж, Улсын Онцгой комисст мэдээлж ажиллахыг Засаг даргын орлогч бөгөөд аймгийн Онцгой комиссын орлогч дарга (Г.Чинбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

